

ZPVT болон ZTT
хамтарсан түншлэл
Жиангсу Жонгтиан
Технологи ХХК

**ХОВД АЙМГИЙН МЯНГАД
СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ
“19.8Мвт НАРНЫ
ЦАХИЛГААН СТАНЦ БАРИХ”
ТӨСЛИЙН ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

УЛААНБААТАР ХОТ

2026 он

АГУУЛГА

ОРШИЛ	4
1. Төслийн товч танилцуулга	5
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт	10
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	10
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	14
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	23
7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	23
8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	32
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	33
14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал	34
15. Тайлбар	34

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн зураг	6
Зураг 2. Төслийн төлөвлөлтийн зураг	7
Зураг 3. Төслийн байршлийн зураг.....	7
Зураг 4. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг.....	8
Зураг 5. Төслийн талбайн мониторингийн цэг	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн нийт усны хэмжээ	9
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	23
Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	24
Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	26
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	29
Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	32
Хүснэгт 9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө	33
Хүснэгт 10. БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал	34

ОРШИЛ

ZPVT болон ZTT хамтарсан түншлэл (Жиангсу Жонгтиан Технологи ХХК РД:9920706) нь Азийн Хөгжлийн Банкны зээлээр хэрэгжүүлж буй Ховд аймгийн Мянгад сумын нутагт баригдах 19.8МВт суурилагдсан чадалтай нарны станц, 4МВт /8МВт.ц багтаамж бүхий Баттарей хуримтлуурын системийн хамт суурилуулах тендерт Ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан (ЕРС) билээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

ZPVT болон ZTT хамтарсан түншлэл (Жиангсу Жонгтиан Технологи ХХК РД:9920706) 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд болон төслийн үйл ажиллагаа, төсөл хэрэгжиж буй талбайн төлөв байдал болон төслийн талбай орчимд хийгдсэн өмнөх шинжилгээний дүнг ашиглаж, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайдын 2019-10-29-ны А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Төслийн барилга угсралтын үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно.

1. Төслийн товч танилцуулга

Эрчим хүчний яамны “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Ховд аймгийн Мянгад суманд “19.8 МВт-ын нарны цахилгаан станц”-ын төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төслийн сонгогдсон байршил бүрийн хувьд зарцуулагдах хөрөнгө оруулалтын хэмжээ 20 сая ам доллар бөгөөд, шаардагдах нийт хөрөнгө оруулалтын 7,373,971 \$-ыг Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар, үлдсэн хэсгийг тус банкны зээлээр санхүүжүүлнэ.

Төслийн талбайд нийт 33,040 ширхэг нарны зайн модулийг 2х27 тоогоор нэг бүл болохуйц байдлаар 612 бүл, 3300 кВт хүчин чадал бүхий 6-н инвертертэй байхаар төлөвлөсөн. Төслийн тооцоонд Ховд аймгийн Мянгад суманд хувьсах талдаа 19.8 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай НЦС болон 4 МВт-ын хүчин чадалтай 8 МВт.ц-ийн багтаамжтай батарей хуримтлуур байхаар төлөвлөсөн байна.

1.1. Төслийн зорилго

Баруун бүсийн эрчим хүчний систем дэх алслагдсан сул цэгүүдээс сонгосон байршилд холбогдон ажиллах батарей хуримтлуур бүхий нарны цахилгаан станцыг байгуулах Төслийн үндэслэл - Монгол улсын засгийн газар (ЗГ) Эрчим хүчний яам (ЭХЯ)- аар дамжуулан Азийн хөгжлийн банк (АХБ) болон Уур амьсгалын стратегийн сан (УАСС)-аас Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилтийг авснаар төсөл хэрэгжих үндэслэл тавигдсан.

1.2. Хөрөнгө оруулалтын хэмжээ

Нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 20 сая ам доллар байхаар тооцоход Мянгад суманд баригдах нарны цахилгаан станцын хүчин чадал 19.8 МВт байх тооцоо гарсан. Хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн хувь (IRR) төслийн ашигласан технологийн төрлөөс хамааран Ховд аймагт (12.1)% ~ (13.27)%-ын хооронд, цэвэр мөнгөний өнөөгийн үнэ цэнэ (NPV) нь 47,408.2 ~ 59,451.3 сая төгрөгийн ашигтай байна. Төсөл хэрэгжих хугацааны тэгшитгэсэн өртөг /LCOE/ нь Ховд аймгийн Мянгад суманд хамгийн бага буюу 195.29 төг/кВт.ц байна.


1.3. Нарны цахилгаан станцын тоног төхөөрөмжийн сонголт

Нарны үүсгүүрийн үндсэн тоноглол болох нарны зайн модуль, инвертерийг манай улсад ашиглагдсан байдал, үйлдвэрлэгчийн найдвартай байдал, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд тавигдах шаардлага хангаж буй эсэх, бага талбайд илүү эрчим хүч үйлдвэрлэх боломж зэрэг хүчин зүйлсэд тулгуурлан, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Tier-1 ангиллын Trina Solar компанийн TSM-NEG21C.20 загварын хоёр талт (bifacial) монокристалл нарны зайн модулийг сонгосон. Тус модуль нь нэг бүр нь 700Вт чадалтай бөгөөд нийт 33,040 ширхэг модулиар станцыг бүрдүүлнэ. Модулиудыг 2х27 загварт бүлэглэн, нийт 612 бүлэг хэлбэрээр угсарч, газар дээр суурилагдах хэлбэртэйгээр байршуулна. Инвертерийн хувьд цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн тогтмол гүйдлийг хувьсах гүйдэл болгон хувиргах зориулалттай Huawei SG3300UD-MV загварын төвлөрсөн (central) инвертерийг ашиглана. Нийтдээ 6 ширхэг, тус бүр нь 3300 кВт чадалтай инвертерийг суурилуулна. Инвертерүүд нь IP66 хамгаалалтын зэрэглэлтэй, -25°C-аас +60°C хүртэлх температурт ажиллах чадвартай бөгөөд хүчдэлийн хэт ачааллаас сэргийлэх ухаалаг хамгаалалтын функцтэй. Төслийн нэг чухал бүрэлдэхүүн болох цэнэг хуримтлуурын систем нь Huawei LUNA2000-2.0MWH-2H1 загварын чингэлэгт литиум-ион батарейн технологид суурилсан. Тус батарейн систем нь нийт 4 МВт чадалтай, 8 МВт.цаг эрчим хүч


хуримтлуулах боломжтой бөгөөд 1 МВт чадал бүхий 4 иж бүрдэл бүхий контейнер хэлбэрээр байршуулна. Энэхүү цэнэг хуримтлуур нь оргил ачааллын үед хэрэглээг тэнцвэржүүлэх, сүлжээнд өгөгдлийг буцаан нийлүүлэх зэрэг олон давуу талтай. Мөн тус системд чадлын хувиргуур (power conversion system, PCS) болон батарейн удирдлагын систем (BMS) суурилуулагдах ба тэдгээрийн ажиллагаа бүрэн автоматжсан, алсын зайн хяналттай байна.

1.4. Нарны цахилгаан станц төлөвлөлт

Сонгосон байршил дахь сайтын боломжит талбайд нийт 33,040 ширхэг нарны зайн модулийг 2х27 тоогоор нэг бүл болохуйц байдлаар 612 бүл, 3300 кВт хүчин чадал бүхий 6-н инвертертэй байхаар төлөвлөсөн. Нарны цахилгаан үүсгүүрийн модулийн налалтын өнцгийг тухайн байршлын онцлогт тохируулан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийг хамгийн өндөр байлгахуйц байрлалд оновчилж 45° байхаар төлөвлөсөн. Нарны цахилгаан үүсгүүрийн модулийн нэг бүлд 2х27 тооны модуль багтах ба нийт 612 бүл байна. Нарны цахилгаан станцын тогтмол гүйдэл талын суурилагдсан чадал 23.13 МВт бол хувьсах гүйдэл талын чадал 19.8 МВт байна. Тогтмол ба хувьсах чадлын харьцаа 1.17 болно. Тус төлөвлөлтийн дагуу барьж байгуулсан нарны цахилгаан станцын үйлдвэрлэл жилд 41,211.21 МВт.ц байх тооцооны үр дүн гарсан. Төслийн талбайн баруун урд хэсэгт дэд станц болон түүний холбогдох бүрэлдэхүүн хэсгүүд, мөн цэнэг хуримтлуурын чингэлэгт батарей хуримтлуурууд, чадлын хувиргуурууд, хүчний трансформаторууд байрласан байна. Нарны цахилгаан үүсгүүрийн модулиудыг цэнхэр өнгөөр ялгаж харуулсан бөгөөд 33,040 ширхэг нарны цахилгаан үүсгүүрийн модулыг 2х27 тоогоор нэг бүл болохуйц байдлаар 612 бүл болгож, 3,300 кВт хүчин чадал бүхий 6 инвертерийн иж бүрэн дэд өртөөнд холбох байдлаар төлөвлөв.




Зураг 1. Төслийн талбайн зураг



Зураг 2. Төслийн төлөвлөлтийн зураг

1.5. Төслийн байршил

Төслийн талбай нь Ховд аймгийн Мянгад сумын нутагт сумын төвөөс 2 км зайд 55 га талбайг хамран оршино.



Зураг 3. Төслийн байршилийн зураг

"Средством одним из них — намеренно введённой тощей" ильн хураана "108 МРт илн нэрхил

✓ **Углеродный стериоидный ислон бичстероидный гормондер:**

➤ СЭХНТ-ийн хүрээнд баригдах “19.8 МВт-ын нарны цахилгаан станц”-ын техник эдийн засгийн үндэслэл.

1.7. Усны хэрэглээ

1. Унд ахуйн хэрэгцээнд

Унд ахуй болон ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах усны хэмжээг БОУАӨЯ ны сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаал “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын хавсралт 11 Мод үржүүлэхэд зарцуулах усны норм (навчит мод, элсэрхэг хөрс 40 ш/л) болон хавсралт 12 “Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангадаг гэр хороолол” нормоор 20 л/хоног/хүн болон ус хэрэглэхээр тооцоход:

Ажилчдын тоо – 10 хүн, ажиллах хоног – 365 хон Тооцоолол: - 10 хүн х 20.0 л/хон = 0.2 м3/хоног (0.002 л/с) буюу 73 м3/жил усыг унд, ахуйд хэрэглэхээр тооцов.

2. Ногоон байгууламжийн усалгаанд

БОУАӨЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралт “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-ын дагуу 2 настай навчит мод = 40 л/мод/хоног нормыг баримтлав. Жилд нийт 12 удаа усална. 500 мод*40 ш/л*12 хон =240 м3/жил усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглана.

3. Нарны дэлгэц угаахад

Нарны дэлгэц угаахад шаардагдах усны хэмжээг тооцоход “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-г ашиглах боломжгүй тул тус төслийн ТЭЗҮ-г ашиглаж тооцов.

➤ Угаах давтамж: жилд 1 удаа

➤ Нэг удаад шаардагдах усны хэмжээ: 32 тн буюу 32 м3 ус *1 удаа=32 м3/жил

➤ Дэлгэцийн тоо: 33,040 ш

➤ 32,000 л/33040 ш дэлгэц=0,96 л

4. Нийт усны хэрэглээ

Төслийн унд ахуйн усны хэрэглээ, нарны дэлгэц угаах усны хэрэглээ болон ногоон байгууламжийн усалгааг нэгтгэн тооцож үзэхэд жилд нийт **345 м3** ус ашиглана.

Хүснэгт 1. Төслийн нийт усны хэмжээ

Усны зарцуулалт	Норм, л	Хэмжээ	Усны хэрэглээ, м3/хоног	Жилийн хэрэглээ, м3/жил
Унд ахуйн усны хэрэглээ	20 л	10 хүн	0.2	73
Нарны дэлгэц угаах усны хэрэглээ	0.96 л	33,040 ш	32	32
Ногоон байгууламжийн усалгаа	40 л	500 ш	20	240 /12 хон/
Нийт			52.2	345

Төслийн нийт ус ашиглалт: 52.2 м3/хоног буюу 0.604 л/с (345 м3/жил)

Төслийн барилга угсралт болон ашиглалтын үед ус ашиглах, хаягдал бохир усны дүгнэлт зөвшөөрлийг холбогдох төрийн байгууллагуудаас авч гэрээ байгуулан ус ашигласаны болон ус бохирдуулсаны төлбөрийг төлж ажиллана.

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Ховд аймгийн Мянгад сум нь аймгийн төвөөс 37 км, Улаанбаатар хотоос 1470 км зайд орших бөгөөд Монгол Алтайн уулархаг бүсийн Алтан хөхий уулын өвөрт байрладаг. Нутаг дэвсгэр нь 325.5 мянган га бөгөөд ихэнх нь бэлчээр, байгалийн задгай усны эх үүсвэр (Ховд гол, нуурууд, булаг шанд)-ээр хангагдсан.

2023 оны байдлаар 3731 хүн амтай, өмнөх оноос бага зэрэг буурсан. Нийт 221.2 мянган толгой малтай бөгөөд мал аж ахуй давамгайлсан эдийн засагтай.

Суманд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв зэрэг төрийн байгууллагууд ажиллаж, нийт 30 гаруй албан хаагчтай ЗДТГ үйл ажиллагаа явуулж байна. Эрүүл мэндийн төв нь 25 ажилтантайгаар хүн амд үйлчилгээ үзүүлдэг.

Боловсролын салбарт 12 жилийн сургууль (423 сурагч, 28 багш), цэцэрлэг (158 хүүхэд, 16 ажилтан) үйл ажиллагаа явуулж байна.

Мөн банк, шатахуун түгээх станц, тоосгоны үйлдвэрүүд ажиллаж, сум нь аймагтаа тоосгоны үйлдвэрлэлээр тэргүүлдэг.

3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Нарны цахилгаан станцын төслийн барилгын үе шатанд байгаль орчинд тодорхой сөрөг нөлөөлөл үүсэх боломжтой бөгөөд үүнд тээврийн хэрэгсэл, газар шорооны ажлаас үүдэлтэй тоосжилт, техник тоног төхөөрөмжөөс ялгарах хорт хий, дуу шуугиан зонхилно. Мөн хөрс хуулалт, овоолго, замбараагүй хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл, элэгдэл үүсэх, шатах тослох материал асгарах зэргээр хөрс болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ургамлын бүрхэвч устах, тоосонд дарагдах, амьтдын амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэх, барилгын нүх шуудуунаас шалтгаалан амьтад эрсдэх магадлал мөн бий.

Түүнчлэн барилгын ажлын явцад ахуйн болон барилгын хог хаягдлын буруу менежментээс үүдэн амьтан хордох, орчны бохирдол нэмэгдэх, ойр орчмын иргэд дуу чимээний нөлөөлөлд өртөх, ажилчид хөдөлмөрийн аюулгүй байдлыг мөрдөөгүй тохиолдолд осол аваарт өртөх зэрэг эрсдэлүүд гарч болзошгүй. Үүнээс гадна төслийн талбай орчимд орших археологийн болон түүх, соёлын дурсгалууд (жишээ нь булш, хадны зураг зэрэг) гэмтэх эрсдэл байж болох тул хамгаалалтын арга хэмжээ зайлшгүй шаардлагатай.

Харин ашиглалтын үе шатанд нарны цахилгаан станц нь агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгаруулалт бараг үүсгэдэггүй, дуу шуугиан багатай тул байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна. Үүний зэрэгцээ эрчим хүчний

найдвартай байдлыг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах, орон нутгийн эдийн засгийг дэмжих, ажлын байр бий болгох зэрэг нийгэм, эдийн засгийн эерэг үр нөлөөг дагуулна.

3.1. Цаг уур, уур амьсгалд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Цаг уурын эрс тэс нөхцөл байдал нь нарны цахилгаан станцад сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй юм.

Аянга цахилгаан, салхи шуурга байгалийн гэнэтийн давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс нарны цахилгаан станцын тоног төхөөрөмжүүдэд гэмтэл, саатал учрах, гэнэтийн болон байгалийн гамшигт үзэгдэлд өртөж болзошгүй юм.

3.2. Агаарын чанарт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Нарны цахилгаан станцын эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаанаас хүлэмжийн хий болон бусад хорт бохирдуулагч агаарт ялгаруулдаггүй, үйлчилгээнд хэрэглэгдэх цөөн тооны тээврийн хэрэгслийг эс тооцвол өөр агаар бохирдуулагч эх үүсвэр байхгүй тул агаарын бохирдол бууруулах тусгайлсан арга хэмжээ шаардлагагүй. Мөн ажилчдын эрүүл мэнд, дуу шуугианаас хамгаалах арга хэмжээг хөдөлмөр аюулгүй байдлын ажиллагаа, эрүүл ахуйн талаар хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлэх үүрэг хүлээх боловч нарны цахилгаан станцын техник, тоног төхөөрөмж нь дуу шуугиан үүсгэдэггүй төсөлд хамрагддаг тул шуугианыг бууруулах арга хэмжээ шаардлагагүй болно.

Барилгын ажлын үе шатанд үүсэх сөрөг нөлөөлөл:

Гол сөрөг нөлөөлөл:

1. Төслийн барилга байгууламжийг барих, суурилуулах, зэрэг үйл ажиллагааны үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, барилгын материалыг хураах талбай болон газар шорооны ажлаас гарсан овоолго зэргээс агаарт тоосжилт үүсэж болзошгүй;

2. Хөрс чулуулгийг хуулах, ухах, зөөх, буулгах, тэгшлэх зэрэг үйл ажиллагаа болон ашиглаж байгаа техник хэрэгслүүдийн хөдөлгөөнөөс дуу шуугиан үүсэж болзошгүй.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

3. Төслийн барилга байгууламжийг барих, суурилуулах, зэрэг үйл ажиллагааны үед ашиглагдах тээврийн хэрэгслүүд, машин механизмуудын яндангаас нүүрстөрөгчийн исэл, хүхэрлэг хий, азотын исэл, нүүрстөрөгчийн давхар исэл, хөө зэрэг бохирдуулагчид их хэмжээгээр ялгарч, агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй;

4. Тээврийн хэрэгсэл барилгын болон газар шорооны ажил гүйцэтгээгүй үед асаалттай байх нь яндангаас агаар бохирдуулах бодисууд ялгарч агаарын найрлагыг өөрчилж бохирдуулж болзошгүй;

5. Машин механизмуудын хөдөлгүүрийн утаа нь байгаль орчныг бохирдуулах нөлөөлөл үзүүлэх төдийгүй, амьсгал боогдуулагч, хорт хавдар үүсгэгч зэрэг хортой бодисууд хүний эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй.

3.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл нь ахуйн хэрэглээнээс гарсан хатуу, шингэн хаягдал машин техник тоног төхөөрөмжийн шатах тослох материалын зохисгүй хэрэглээний улмаас үүсэн хаягдлаар газрын хөрс бохирдох магадлалтай.

Барилгын ажлын үе шатанд үүсэх сөрөг нөлөөлөл:

Гол сөрөг нөлөөлөл:

1. Барилга байгууламж барих үед хөрс хуулах, түрэх, овоолго хийх, хучилт хийх зэрэг талбайд хөрсний эвдрэл, элэгдэл үүснэ;

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

2. Барилгын ажлын үед ашиглах машин, механизмуудад эвдрэл, гэмтэл гарсан үед шатах, тослох материал асгаралт, шүүрэлт үүсэж хөрсийг бохирдуулж болзошгүй;

3. Барилгын ажлын үед машин техникийн маршрутын бус хөдөлгөөн зэргээс үүдэн бусад хөрсөн бүрхэвч элэгдэж, доройтож болзошгүй;

3.4. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

СЭХНТ-ийн хүрээнд баригдах нарны цахилгаан станц нь Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамаарах манай орны баруун бүсэд орчих мөнх цас, мөсөн оргил бүхий өндөр уулс гүн өргөн хавцал хөндий, ойт хээр, хээр тал, говь цөлийн бүсэд хамрах Хар нуур-Ховд голын сав газарт багтах бөгөөд Мянгад сумын төвийн зүүн хойно Галтын бор толгойн бэлд тэгш гадаргуутай хэсэгт байрлана.

3.4.1. Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны улмаас гадаргын болон газрын доорх усны нөөц чанарт дараах нөлөөлөл учирч болзошгүй. Үүнд:

Барилгын ажлын үе шатанд үүсэх сөрөг нөлөөлөл:

Гол сөрөг нөлөөлөл

1. Тээврийн хэрэгслээс шатах, тослох материал асгарч хөрсөнд шингэснээр газар доорх усыг бохирдуулж болзошгүй;

2. Барилга байгууламж барих үеийн бетон зуурмагийн ажилд ус хэрэглэх ба уг хэрэглэх усны хэрэглээг хяналтгүй зарцуулснаар усан хангамжийн газар доорх усны нөөцөд нөлөө үүсэж болзошгүй;

3.5. Ургамлын нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Нарны станцын төслийг хэрэгжүүлэх явцад сумаас зааж өгсөн газарт 500 мод бүхий зурвас, зүлэгжүүлэлт хийх төлөвлөгөөг тооцооны хамт төлөвлөгөөнд тусгасан.

Барилгын ажлын үе шатанд үүсэх сөрөг нөлөөлөл:

Гол сөрөг нөлөөлөл:

1. Барилгын ажлын үед хөрстэй хамт ургамлан бүрхэвч хуулагдана;

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

2. Барилгын ажлын үед ашиглах машин механизмуудын нөлөөгөөр ногоон байгууламж тоосонд дарагдаж болзошгүй;

3.6. Амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Нарны цахилгаан станцын барилга угсралтын ажлын явцад ахуйн болон техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад нөлөөлөл үзүүлэх, бохирдуулсан тохиолдолд доорх байдлаар амьтны аймагт нөлөөлж болзошгүй юм. Үүнд:

1. Барилгын ажлын үед ухсан нүх зэрэгт мал амьтан унаж эрсдэх нөлөөлөл үүсэж болзошгүй;
2. Ахуйн болон техникийн гаралтай хог хаягдлыг хог хаягдлын цэгт удаан байлгах, муудсан хаягдлыг суурин амьтад идэх, хордох, улмаар үхэлд хүрэх зэрэг болно.

Төслийн талбайн байршлын онцлог, нарны дэлгэцийн хамрах талбайн хэмжээ зэргээс харвал нарны дэлгэц шувуудад сөрөг нөлөө үзүүлэхгүй.

3.7. Түүх, соёлын өвд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Өнөөгийн байдал

Археологийн олдворууд:

- Хүннүгийн үеийн булшнууд: Мянгад сумын нутагт Хүннүгийн үеийн олон булш, хүрээлэн буй газрууд олддог. Эдгээр булшнууд нь Хүннүгийн соёл, зан заншлын талаарх чухал мэдээллийг өгдөг. Хүннүгийн булшнуудаас алт, мөнгөн эдлэл, зэвсэг, хувцасны чимэглэл зэрэг олон төрлийн эд зүйлс олддог.
- Хадны зураг: Мянгад сумын нутагт эртний хүмүүсийн үлдээсэн хадны зураг олддог. Эдгээр зураг нь ан агнах, амьтдыг дүрсэлсэн байдаг бөгөөд эртний хүмүүсийн амьдрал, соёл, шашны тухай ойлголт өгдөг.
- Чулуун зэвсэг, багаж хэрэгсэл: Эртний чулуун зэвсэг, багаж хэрэгсэл нь Мянгад сумын нутагт олддог. Эдгээр нь хүмүүсийн эртний амьдрал, аж ахуй, технологийн түвшинг илтгэдэг.

Түүх соёлын дурсгалт зүйлс:

- Овог аймгийн дурсгал: Мянгад сум нь Монголын овог аймгийн түүхтэй холбоотой олон дурсгалт газруудтай. Эдгээр газрууд нь тухайн үеийн овог аймгийн нийгэм, засаг захиргааны тогтолцоог судлахад чухал ач холбогдолтой.
- Буддын шашны сүм хийд: Мянгад сумын нутагт буддын шашны сүм хийдүүд байдаг бөгөөд эдгээр нь тухайн бүс нутагт буддын шашин хэрхэн тархсан, хүмүүсийн шашны итгэл үнэмшлийг илтгэдэг.

Мянгад сумын нутагт явуулсан археологийн хээрийн хайгуул судалгаагаар 1 хүрэл зэвсгийн үед хамаарах дурсгал илрүүлэв. Судлаачид хиргисүүр хэмээх энэхүү өвөрмөц дурсгалыг НТӨ 1300-800 оны хооронд холбогдуулан авч үздэг бөгөөд одоогоос 2800-3300 жилийн өмнө холбогдох тахилга тайлга болон оршуулгын зан үйлийн зориулалттай хэмээн үздэг. Хайгуулын талбай нь зүүн талаараа одоо байгаа нарны цахилгаан станцын хашаатай нийлэх бөгөөд хойд талаараа хадтай жижиг уулс, зүүн болон өмнө талаараа тэгш талархаг байдалтай аж. Бидний илрүүлсэн дурсгал эрт цагт тоногдсон байдалтай шинж тэмдэг ажиглагдана. Дурсгалын зарим зохион байгуулалтыг гадаргын хөрсний нүүдэл дарсан байна.

3.8. Нийгэм, эдийн засагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Нарны цахилгаан станцын төслийн үйл ажиллагаа эхэлснээр эрчим хүчний чадлын коэффициентыг дээшлүүлэх, цахилгаан дамжуулах сүлжээний дамжуулах чадварыг нэмэгдүүлэх, эрчим хүчний алдагдлыг бууруулах, хүчдэлийн хэмжээг тохируулах зэргээр сүлжээний горим, үр ашгийг дээшлүүлэх чухал ач холбогдолтой

төсөл юм. Төсөл хэрэгжих хугацааны туршид 736.5 ~ 796.9 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ.

Барилгын ажлын үе шатанд үүсэх сөрөг нөлөөлөл:

1. Барилгын ажлын үед ашиглаж буй машин тоног төхөөрөмжийн дуу шуугиан нь ажиллагсад болон ойр орчмын айл өрхүүдэд, ойролцоо үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд нөлөөлөх шуугианы эх үүсвэр болно;

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

Барилгын ажлын үед ажилчид, ялангуяа хүнд машин механизмтай харьцан ажилладаг ажилчид, ойр орчмын хүмүүс хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөөгүйн улмаас осол аваарт өртөж болзошгүй;

1. Барилгын ажлын үед машин техникийн дуу чимээний нөлөөлөлд ойр орчмын айлууд өртөж болзошгүй;

Төсөл хэрэгжсэнээр нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллүүд:

1. Орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого орох, ажлын байр нэмэгдэх;
2. Сэргээгдэх эрчим хүчний салбарт орчин үеийн шинэ технологи нэвтрэх, эдийн засгийн үр ашиг нэмэгдэх, хорт хийн ялгарлыг багасгахад тодорхой хувь нэмэр оруулна;
3. Төслийн үйл ажиллагаа явагдсанаар эрчим хүчний чадлын коэффициентийг дээшлүүлэх, цахилгаан дамжуулах сүлжээний дамжуулах чадварыг нэмэгдүүлэх, эрчим хүчний алдагдлыг бууруулах, хүчдэлийн хэмжээг тогтворжуулах зэргээр сүлжээний горим, үр ашгийг дээшлүүлэх зэрэг болно.

4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ий тайлан, БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Төслийг хэрэгжүүлэх явцад БОННУ-ний тайлан, БОМТ-нд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Цаг уур, уур амьсгал									
1	Цаг уурын гэнэтийн аюултай үзэгдлийн улмаас болзошгүй осол аваар гарах	Хэт халах, хүчтэй аадар бороо орох, хүчтэй салхилах, шороон шуурга шуурах, үер буух зэрэг байгаль цаг уурын аюултай үзэгдлийн үед барилга газар шорооны ажил болон материал тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоох, техник хэрэгслүүдийг унтрааж, ажиллагааг зогсоох	Төслийн талбай орчим	-	-	-	-	2026 он	-Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он - Машин механизмуудын аюулгүй ажиллагааны дүрэм
Агаарын чанар									
2	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Шороон замаас үүсэх тоосжилтыг усалгаа хийж бууруулах	Төслийн талбай орчим	-	Үйл ажиллагааны зардал			2026 он	-Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016

3	Материал тээвэрлэх болон бусад үйл ажиллагааны үед тээврийн хэрэгсэл, машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүсэх	Шороон замаар зорчих тээврийн хэрэгслүүдийн хурдыг 30-40 км/цаг-аар хязгаарлах буюу энэ хурднаас хэтрүүлэхгүй байх зохицуулалт хийх	Төслийн талбай орчимд	-	-	-	-	2026 он	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
4	Газар шорооны ажлын үед ашиглах элс, хайрга, цемент зэрэг	Полиэтилен болон даавуун хучлагаар барилгын материалын овоолгыг (элс, хайрга, цемент г.м) хучих	Төслийн талбай орчимд	-	-	-	500.0	Салхин ы хурд ихсэх үед	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
5	материалуудын овоолгоос салхины үйлчлэлээр тоос босох	Задгай талбайд овоолох барилгын материалыг газрын гадаргаар тархахаас сэргийлж хаалт, хашилт хийх	Төслийн талбай орчимд	-	Үйл ажиллагааны зардал			2026 он	
6	Хүнд даацын машин механизмын дутуу шаталтат хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч агаар бохирдуулах	Нийт машин механизмуудыг үзлэг оношилгоонд хамруулж, шаардлагатай бол хөдөлгүүрийг шинэчилж сайжруулах.	Хүрээлэн буй орчин хүний эрүүл энд	-	Үйл ажиллагааны зардал			-	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 5885 : 2008
(Агаарын чанар)							500.0		
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	Газрын гадарга, хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг элэгдэх,	Барилгын материалуудыг аль болох нэг цэгт төвлөрүүлэх	Төслийн талбайн хөрс, ургамлан бүрхэвч	-	-	-	-	2026 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 он Байгаль орчин. Газар. Газар ашиглалт. Нэр

2	ургамлан нөмрөг устах	Ажлын үед овоолсон шороо болон бусад хэт налуу орчныг багасгах		-	-	-	-	2026 он	томьёо, тодорхойлолт MNS 3473:1983
3		Экскаватороор ухсан нүхийг ил орхихоос сэргийлэх		-	-	-	-	2026 он	
4	Барилгын материалын болон ахуйн хаягдлаар орчныг бохирдуулах	Барилгын материалын хаягдлыг богино хугацаанд төслийн талбайгаас зайлуулах, хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлэх, үүссэн хаягдлыг хийсэж тархахааргүй битүүмжлэл сайтай цэгт түр хадгалах арга хэмжээ авах	Төслийн үйл ажиллагаа н аас үүсэх хог хаягдал	-	Зардлыг хог хаягдлын төлөвлөгөөний хэсэгт тусгав			2026 он	Хог хаягдлын тухай хууль, 2017 он - Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344: 2011
5	Бүх төрлийн шатах, тослох материалаар ажилладаг	Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг нэн даруй хусаж аван хөрсний гүн рүү нэвчихээс сэргийлэх	Төслийн талбайн хөрс, ургамлан бүрхэвч	-	-	-	-	2026 он	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
6	машин механизм, тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үед шатах тослох материал асгарч хөрс бохирдуулах	Шатах тослох материал их хэмжээгээр асгарсан бол элс, даавуу зэрэг шингээгч материалд шингээн авч битүү саванд хийх, асгарсан хэсгийн хөрсийг хуулж авах	Төслийн талбайн хөрс, ургамлан бүрхэвч	-	-	-	-	2026 он	
Дүн (Газрын гадарга, хөрсөн бүрхэвч)							-		
Гадаргын болон газрын доорх ус									
1	Гадаргын ус хатуу, шингэн	Голын усанд машин угаах, голын ойр орчимд	Төсөл хэрэгжих	-	-	-	-	2026 он	Усны тухай хууль, 2012 он - Монгол Улсын

	хаягдлаар бохирдох	бие засах, хог хаягдал ил задгай хаяхгүй байх талаар барилгын ажилчдад хатуу анхааруулах ба үүнд талбайн инженер хатуу хяналт тавьж ажиллах	талбай түүний орчим					байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 6 дугаар сарын 05- ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаал, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”
2	Гадаргын болон газрын доорх ус ахуйн шингэн хаягдлаар бохирдох	Стандартын шаардлагад нийцсэн ажилчдын бие засах газар (эрэгтэй, эмэгтэй) буюу ариун цэврийн байгууламж барих	Төсөл хэрэгжих талбай түүний орчим	-	Зардлыг хог хаягдлын төлөвлөгөөний хэсэгт тусгав		2026 он	- Усны тухай хууль, 2012 он - Хог хаягдлын тухай хууль, 2017 он - Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 6 дугаар сарын 05- ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаал, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”
Дүн (Гадаргын болон газрын доорх ус)							-	
Ургамлан нөмрөг								

1	Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг устах, доройтох	Барилгын ажлын төлөвлөлт, газар ашиглалтыг зөв хийж ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх талбайг хамгийн бага хэмжээнд байлгах	Төслийн талбай орчим	-	-	-	-	2026 он	Байгалийн ургамлын тухай хууль, 1995 - Ургамал хамгааллын тухай хууль, 2007 он - Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 08 дугаар сарын 25 – ны өдрийн 153 дугаар тогтоол, Ховор ургамлын жагсаалт
Дүн (Ургамлан нөмрөг)								-	
Амьтны аймаг									
1	Хууль бус ан агнуурын үйл ажиллагаа явагдах	Барилгын ажилчдад хууль бус ан агнуур хийхгүй байх, худалдаалахгүй байх талаар анхааруулга өгч, хяналт тавьж ажиллах	Төслийн талбай орчим	-	-	-	-	2026 он	Амьтны тухай хууль, 2012 он - Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 7 дугаар тогтоол, Ховор амьтны жагсаалт
Дүн (Амьтны аймаг)								-	
Нийгэм, хүний эрүүл мэнд									
1	Орон нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах, нөлөөлөлд өртөмтгий иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Барилгын материал тээвэрлэж буй машин сургууль, эмнэлэг, суурьшлын бүс зэрэг чимээнд мэдрэг газруудаар дайрч өнгөрөх, эдгээр газрын ойр орчимд явахдаа хурдаа хасах, дуут дохио ашиглахгүй байх	Хүрээлэн буй орчин хүний эрүүл мэнд	-	-	-	-	2026 он	-
2	Орон нутгийн иргэдэд тодорхой мэдээлэл	Барилгын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх хугацаа, хийгдэх ажлуудын талаар	Төслийн талбай орчим	-	-	-	500.0	2026 он	Барилгын тухай хууль, 2016 он

	өгөөгүйн улмаас ул ойлголцол үүсэх	иргэдэд мэдээлэл өгөхүйц мэдээллийн самбарыг барилгын талбайн орчимд байршуулах							
3		Барилгын ажлын явцад орон нутгийн иргэдээс ирсэн аливаа санал гомдлыг хүлээн авч богино хугацаанд шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд нэгдсэн журмаар мэдээлэл өгөх	Төслийн талбай орчим	-	-	-	-	2026 он	-
4	ХАБЭА-н дүрэм зөрчигдөх, осол аваар гарах	Барилгын ажилчдад ажил эхлэхээс өмнө ХАБЭА-н зааварчилгаа өгч, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх	Нийт ажилчид	-	Үйл ажиллагааны зардал			2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он - Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага MNS 6231 : 2011 - Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал MNS 4931: 2000 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас Ерөнхий шаардлага MNS ISO 13688 : 2000
5	Анхны тусламж үзүүлэх эм тариа, багаж хэрэгсэл байхгүйн улмаас ослын нөхцөлийг хүндрүүлэх	Ажилчдад аливаа болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгааг өгч, анхны тусламжийн эм	Нийт ажилчид	-	-	-	500.0	2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он

		тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах							
6		амгийн ойр байршилтай эмнэлэг, түүнд хүрэх хамгийн дөт замыг тодорхойлох		-	-	-	-	2026 он	
7		Хамгийн ойр байгаа эмнэлэг хүрэх зам, холбоо барих мэдээллийг агуулсан зургийг ажлын талбай бүрд байршуулах		-	-	-	-	2026 он	
8	Гал унтраах багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаагүйн улмаас ослын нөхцөлийг хүндрүүлэх	Галын аюулын үед хэрэглэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг байнга цэнэглэж гэнэтийн болзошгүй аваар ослын үед хэрэглэхэд бэлэн байлгах	Төслийн талбай	-	-	-	400.0	2026 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он - Хөдөлмөр хамгааллын систем.Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244 : 1994 - Галын аюулаас хамгаалах нийтлэг асуудал. Галын ангилал MNS 4284:2017
Дүн (Нийгэм, хүний эрүүл мэнд)							1400.0		
НИЙТ ДҮН							1900.0		

6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд 500 ширхэг модыг төслийн талбайд тарихаар БОННУ-ний БОМТ-нд тусгасан боловч эрчим хүчний дэд бүтцийн орчимд модлог ургамал тарих нь аянга буух эрсдэлийг нэмэгдүүлдэг тул Мянгад сумын төвийн хойд хэсэгт, Мянгад - Дөргөн чиглэлийн авто замын хажууд тарихаар төлөвлөсөн. Мод тарих газрын байршлыг Мянгад сумын засаг дарга, байгаль орчны улсын байцаагч болон газрын даамал зэрэг холбогдох албан тушаалтнуудтай зөвшилцөн чиглэл авч заалгуулсан болно.

Хүснэгт 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Мод тарих	Төслийн талбайд мод бут тарина	ш	500	5,000,000.0	2026	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2	Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх Бусад зардал	/Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ/	Ажилчны хөлс	Ажилчин	2	Үйл ажиллагааны зардал	2026	Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2011
Нийт дүн						5,000,000.0		

7. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд зайлшгүй нүүлгэх шаардлагатай иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй болно.

8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллана Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;
- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана;

Хүснэгт 4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээн ий цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл” УТҮГ-ийн хүсэлтээр ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хайгуул судалгааны анги 2025 оны 05 сарын 07-ний өдрөөс 09-ний өдөр Ховд аймгийн Мянгад сумын Баянхошуу багийн нутагт ажилсан. Хайгуул судалгааны явцад нийт 1 тооны дурсгал илрүүлсэн. Уг дурсгал нь хүрэл зэвсгийн үеийн Хиргисүүр (НТӨ 1300-800 он) хэмээх нүсэр бүтэц зохион байгуулалттай чулуун байгууламж байна. “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл” УТҮГ–с бидэнд ирүүлсэн талбайд 1 дагуултай 1 том хиргисүүр байгааг илрүүлснээс гадна бүтээн байгуулалт хийх явцад уг талбайн гадна дурсгал өртөж магадгүй хэмээн үзээд хойд зүгт орчин үеийн оршуулгын газар, зүүн зүгт	Талбайг бүхэлд нь ашиглах бол Монгол Улсын Соёлын өвийн тухай хуулийг хэрэгжүүлж археологийн н малтлага судалгаа хийлгэж дээрх дурсгалыг чөлөөлүүлэх	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээн д	-	Үйл ажиллагааны зардал		2026 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/ , Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд

	хогийн цэг, түүний хажуугаар зүүн хойноос баруун урагш чиглэсэн тод шороон замын дагуу болон өмнө зүгт хатуу хучилттай авто замын далан хүртэл үзэж нягталсан.	шаардлагат ай юм.					
--	--	-------------------	--	--	--	--	--

9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн барилга угсралтын ажлын үед нийт 80 хүн ажиллах ба хоногт 1 хүн дунджаар 0.52 кг хатуу хог хаягдал гаргана гэж тооцвол хоногт $80 * 0.52 = 42$ кг, $240 * 42 = 10080$ кг болно. Нийтдээ 10.тн хог хаягдал гарах урьчилсан тооцоо гарч байна.

Хүснэгт 5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлын цэг, ангилан ялгах талбай, станцын орчимд бохирдол үүсэж болзошгүй тул хог хаягдлын талаар хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ажиллагааг ээлтэй арга нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх	Барилгын ажлын үед үүсэх хог хаягдлыг Мянгад сумын эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээ байгуулж зайлуулах	Төслийн үйл ажиллагаан аас үүсэх хог хаягдал	-	Үйл ажиллагааны зардал			2026 он	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон холбогдох тогтоол, дүрэм, журам
2		Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	Төслийн үйл ажиллагаан аас үүсэх хог хаягдал		800.0			2026 он	
3		Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй	Төслийн нийт ажилчид					2026 он	

	нөлөөллийг бууруулах	зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах					
Нийт дүн					800.0		

10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас осол аваар гарах эрсдэлтэй.	Барилга, газар шорооны ажилд хэрэглэх машин механизм, техник тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байх	Төслийн талбай	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал			2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он - Барилгын тухай хууль, 2016 он - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 4968 : 2000
2		Хэрэв ажлын талбай дээр машин механизм, тээврийн хэрэгсэл эвдэрсэн бол засварын газарт шаардлагатай бүх засвар үйлчилгээг хийсний дараа үйл ажиллагаа явуулах							

3	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаагүй эсвэл хэрэглээгүй ХАБЭА-н дүрэм	Барилгын талбай дээр ажиллах бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж, хэрэглүүлж хэвшүүлэх	Ажилчдад	Тогтмол	Үйл ажиллагааны зардал			2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он - Тусгай зориулалтын ажлын хувцас. Ерөнхий шаардлага MNS 6231 : 2011 253 Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага, ангилал MNS 4931 : 2000 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, амгаалалтын хувцас - Ерөнхий шаардлага MNS ISO 13688 : 2000
4	зөрчигдсөн үед болзошгүй осол аваарт өртөх	Бүх ажилчдад ХАБЭА-н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХАБЭА-н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг барилгын талбай дээр ажиллахыг хориглох, үүнд ХАБЭА-н ажилтан байнга хяналт тавьж хариуцлагатай ажиллах	Ажилчдад	-	-	-	-	2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он - Барилгын тухай хууль, 2016 он - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 4968 : 2000
5	Машин механизмын ашиглалтын ХАБЭА-н дүрэм зөрчигдөж осол аваарт өртөх	Барилгын материал ачиж буулгах, өргөх зэрэг эрсдэлтэй алхмуудыг ХАБЭА-н инженерийн хараа хяналтад гүйцэтгэх ба аюулгүй байдлын ажилтан шаардлагатай тохиолдолд зааварчилгаа өгөх	Төслийн талбай болон түр зам дагуу	-	-	-	-	2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он - Барилгын тухай хууль, 2016 он - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих

									ерөнхий шаардлага MNS 4968 : 2000
6	Ослын нөхцөл хүндрэх	Ажилчдад анхан шатны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах	Ажилчид	-	-	-	-	2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он
7	Ослын нөхцөл хүндрэх	Барилга, газар шорооны ажил явагдах талбайн орчимд анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, санамж байрлуулах, хязгаарлалтын бүс тогтоох	Төслийн талбайн болон түр зам дагуу	-	-	-	1000.0	2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он - Барилгын тухай хууль, 2016 он
8	Болзошгүй аюул ослын улмаас гал гарах	Галын аюулгүй байдлыг хангаж, гал унтраах анхан шатны болон суурин тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг байршуулах, галын хор цэнэгтэй эсэхийг байнга шалгаж, цэнэг нь дууссан бол цэнэглүүлж байх	Төслийн талбайд	-	Үйл ажиллагааны зардал			2026 он	Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015 он - Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244 : 1994
9	Байгаль, цаг уурын гэнэтийн аюултай үзэгдлийн улмаас осол гарах	Цаг агаарын аюулт үзэгдэл болж болзошгүй сэрэмжлүүлэг зарласан өдрүүдэд бүх ажилчдад дуулган, сонор сэрэмжтэй ажиллахыг сануулах, аян замд гарахгүй байх, төслийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийх, онцгой тохиолдолд	Төслийн талбайд	-	-			2026 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он


		ажиллуулахгүй байх арга хэмжээ авах					
10		Шороон шуургатай өдрүүдэд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдад хязгаарлалт хийх, сонор сэрэмжлүүлгийг өндөржүүлэн ажиллах					
Нийт дүн					1000.0		

11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар орчин								
1	SO ₂ , NO ₂ , CO, PM ₁₀ , PM ₂₅ Гадна болон дотор орчны дуу чимээний түвшин (Мкг/м ³)	Төслийн талбайд 1. 48°15'13.61"N; 91°56'5.29"E 2. 48°15'4.16"N; 91°56'2.23"E 3. 48°14'55.95"N; 91°56'11.42"E	Улиралд 1 удаа (4-р сар, 7-р сар, 10-р сар)	3 удаа	250.0	700.0	Ховд аймгийн Ус Цаг уур, орчны шинжилгээний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, дээжлэлт болон шинжилгээний ажлыг зохион байгуулна	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага
Нийт					700.0			
Усан орчин								
2	Ерөнхий хими, бактериологи (Мг-экв/дм ³ , см, балл, мг/дм ³)	Унд, ахуйн ус 1. 48°14'54.89"N; 91°55'44.48"E	Улиралд 1 удаа (4-р сар, 7-р сар, 10-р сар)	3 удаа	110.0	330.0	Ховд аймгийн Ус Цаг уур, орчны шинжилгээний төвтэй хамтран	MNS 0900:2018 "Хүрээлэн буй орчин. Эрүүл

							ажиллах гэрээ байгуулж, дээжлэлт болон шинжилгээний ажлыг зохион байгуулна	мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
Нийт						330.0		
Хөрсөн бүрхэвч								
3	Хөрсний хүнд металлын агууламж (рН, ялзмагийн агууламж, ялзмагт давхаргын зузаан, механик бүтэц, нийт азот, нийт фосфор, хүнд металлууд)	Төслийн талбайд 1. 48°15'13.02"N; 91°56'15.67"E 2. 48°14'58.95"N; 91°56'3.88"E 3. 48°14'56.19"N; 91°56'18.94"E	Улиралд 1 удаа (4-р сар, 7-р сар, 10-р сар)	3 удаа	170.0	500.0	Ховд аймгийн Ус Цаг уур, орчны шинжилгээний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, дээжлэлт болон шинжилгээний ажлыг зохион байгуулна	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Нийт						500.0		
Нийт							1530.0	



Зураг 5. Төслийн талбайн мониторингийн цэг

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Төслийн хүчин чадал энэхүү тайланд тусгагдсанаас өөр нэмэлт өөрчлөлт орох бүрд дахин байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатай.	Тохиролцох	Төсөл хэрэгжих хугацаанд	Төсөл хэрэгжүүлэгч	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 7.4, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам (Засгийн газрын 374 тогтоолын 2-р хавсралт) ын 4.13- заалт
2	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Тохиролцох	Төсөл хэрэгжих хугацаанд	Төсөл хэрэгжүүлэгч	Төсөл хэрэгжүүлэгч
3	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжих хугацаанд	Төсөл хэрэгжүүлэгч	Төсөл хэрэгжүүлэгч
4	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОУАӨЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	Дотоод төлөвлөлтөөр	12-р сард	Төсөл хэрэгжүүлэгч	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОУАӨЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам

5	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Дотоод төлөвлөлтөөр	Төсөл хэрэгжих хугацаанд	Төсөл хэрэгжүүлэгч	Төсөл хэрэгжүүлэгч
6	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	10000.0	8-р сард	Төсөл хэрэгжүүлэгч	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
	Нийт	10000.0			

13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	БОУАӨЯам	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	12-р сард	Төлөвлөгөө батлуулах	БОУАӨЯ
2	Аймгийн Байгаль орчны газарт	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	11-р сарын 1-ний дотор	Тайлан хянуулах	Аймгийн БОГ
3	Ховд аймгийн Мянгад сумын ИНХ (нөлөөллийн бүсэд оршин суугчид)	Танилцуулга, илтгэл болон мэдээлэл өгч хурлаар хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдэр гарган танилцуулах	Жилд 1 удаа	Инженер техникийн ажилтан	Төслийн удирдлага Орон нутгийн ЗДТГ болон төслийн талбайд

14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал

Төслийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төслийн БОННУ-ний тайлангийн хавсралт 2025-2029 оны БОМТ-нд тусгасан төсвийг үндэслэн 2026 онд нийт 20,230.000 (хорин сая хоёр зуун гучин мянга) төгрөгийн зардал төлөвлөв.

Хүснэгт 10. БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал

№	БОМТ-ны хүрээнд хийх ажлын багц	Нийт тооцсон зардал /мян.төг/	Нийт дүнд эзлэх хувь
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1900.0	9.39%
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5000.0	24.72%
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө	-	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	800.0	3.95%
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1000.0	4.94%
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1530.0	7.56%
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10000.0	49.44%
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	-	-
НИЙТ		20,230.0	100%

15.Тайлбар

Төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлангийн 2025-2029 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүснэгтэд төлөвлөсөн зардал нь тус төлөвлөгөөний Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлын нэгтгэл хүснэгтэд тусгагдсанаас өөр буюу жил бүр 800.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байх тул хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүснэгтэд төлөвлөсөн зардалыг баримтлан төлөвлөсөн болно.

Мөн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлын нэгтгэл хүснэгтэд орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын зардалыг төсөл хэрэгжих эхний жилд 5070.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан зүлэгжүүлэх ажил нь 2025-2029 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2027 оноос эхлэн хийгдэхээр төлөвлөсөн тул 2026 онд зөвхөн 500 ширхэг мод тарих зардлыг буюу 5000.0 мянган төгрөгийг орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан болно.